

Малын ажил ба Тариалангийн хэлтэс

1925-12-11-нд Засгийн газрын 44-р хурлаар Хотын захиргааг жинхэнэ болгож, дүрмийг улсын бага хурлын тэргүүлэгчдэд явуулан батлуулахаар тогтоожээ.

1925-12-11-нд Улсын 2 дугаар Их хурлаар хотын захиргааны дүрэм дөчин есөн зүйлийг баталсан байна. тусгай дүрмээр хотын хэмжээнд дээр ажиллах газрууд

Хотын захиргааны гүйцэтгэх газар нь долоон тэргүүлэгчидтэй, түүний дарга, орлогч, нарийн бичгийн дарга нар нь товчоо болон бүрэлдэж байсан бөгөөд хэлтсүүд нь Ерөнхий хэлтэс, Ардыг гэгээрүүлэх хэлтэс, Ардын эрүүлийг сахих хэлтэс, Аж үйлдвэрийн хэлтэс /энэхүү хэлтэст санхүү, аж ахуй, тоо бүртгэх салбарууд хамаарагдаж байв/-тэй байхаар заажээ. Хэлтсүүд нь тухайн үеийн байдлаас өөрчлөгдөж байжээ. Албан газар, цэрэг, үйлдвэрийн хэлтсүүдтэй болсон байна.

1925 онд хотын захиргаа нь 6 хэлтэс, 104 орон тоотой байв.

Улсын 2 дугаар их хурлын шийдвэр болон Засгийн газрын 22 дугаар хурлын 7-р зүйлийг үндэслэн 1926-9-3-нд Засгийн газрын 35 дугаар хурлын 12 дугаар зүйлээр 1927-1-1-нээс эхлэн хотын захиргааны газрыг Дотоод яамны харьяанаас өөрчилж тусгай эрхтэй биеэ даасан газар болгохоор заажээ.

1930 онд батлагдсан Улаанбаатар хотын захиргааны дүрмийг шинэчлэн баталж, эл дүрэмд хотын захиргаа нь Сайд нарын Зөвлөлийн шууд харьяалалд засаг захиргааны нэгж болохыг заасан

1931-3-29-нд Засгийн газрын эрхлэх товчооны 15-р хурлын 3 дугаар зүйлээр Засаг захиргааны газруудад тамга, тэмдэг гэж давхар олгохыг зогсоож ганц тамга олгох, дөрвөлжин маягийг өөрчлөн дугуй хэлбэртэй болгохоор тогтоожээ.

1931-9-7-нд Засгийн газрын 20-р тогтоолын 4-р зүйлээр Төв аймаг, хотын захиргааг нэгтгэх тухай асуудал боловсруулах комиссыг томилсон байна.

1931-9-21-нд УБХ-ын тэргүүлэгчид, Засгийн газрын хамтарсан хурлын тогтоолоор Улаанбаатар аймгийн захиргааг гишүүд 11, орлогчдыг 5 хүнээр аймгийн захиргааны байгуулалтыг тэргүүлэгч, орлогч, нарийн бичгийн дарга, ерөнхий хэлтэс, цэргийн хэлтэс, хөдөө аж ахуйн хэлтэс, санхүүгийн хэлтэс, хотын нийтийн аж ахуйг эрхлэх хэлтэс, ардыг гэгээрүүлэх явдлын хэлтэс, Цагдан сэргийлэх явдлын хэлтэс, Улсын хянан байцаах бүртгэлийг Эрхлэх товчоо зэрэг зохион байгуулалтаар тогтоожээ.

1932-8-5 нд Сайд нарын Зөвлөлийн 7-р тогтоолын 11-р зүйлээр Улаанбаатар аймгийн захиргааны зохион байгуулалтыг

- 3-5 хүнтэй тэргүүлэгчид

- Малын ажил ба хадлан тариалангийн хэлтэс

1932 оны 10 сард Улаанбаатар хотын захиргааг Төв аймагтай нэгтгэж Улаанбаатар аймгийн Захиргаа болгосон.

1933 оны СнЗ дахин шинэ дүрэм баталж УБХ-ын захиргааг СнЗ-д шууд харьяалуулан захирагдах засаг захиргааны нэгж болгосон. тэр жилдээ хотыг 6 хороо болгож хороодын дарга нарт сумын даргын эрх үүргийг гүйцэтгүүлэв.

1933 оны 12 дугаар сарын 29-нд Сайд нарын Зөвлөлийн 42 дугаар тогтоолын 4 дүгээр зүйл ээр 1930 онд батлагдсан Улаанбаатар хотын захиргааны дүрмийг шинэчлэн баталж, эл дүрэмд хотын захиргаа нь Сайд нарын Зөвлөлийн шууд харьяалалд засаг захиргааны нэгж болохыг заасан. 1937-4-23-нд Сайд нарын Зөвлөлийн 12 дугаар хурлын 4-р зүйлээр Нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталжээ.

1937-4-23-нд Сайд нарын Зөвлөлийн 12 дугаар хурлын 4-р зүйлээр Нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталжээ. - Хотын прокурорууд

- Хотын шүүх таслах газар

- Хотын хоршооны байгууллагууд

- Барьцаалан зээлдүүлэх ламфортын газар

- Хотын доторхи артель, нэгдэл, үйлдвэр, мал эмнэлгийн ажил явуулах удирдлага нөлөөг үзүүлнэ гэжээ.

1972-6-16-нд Сайд нарын Зөвлөлийн 232-р тогтоолоор 1972-7-1-нээс эхлэн Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанд хөдөө аж ахуйн хэлтэс байгуулж орон тоог хэлтсийн дарга 1, мэргэлтэн 4, ня-бо 1, бүгд 6 нэгчээр тогтоогоод тус хэлтсэд шувуун фабрик, гахайн завод, амгалангийн сангийн аж ахуй, хотын мал эмнэлэг, нэгдлийн захын конторыг харьяалуулжээ.